Төв аймгийн Баян сумын Засаг дарга нь сумын хэмжээнд төр засгийн бодлого, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт шинжилгээ хийж, үр дүнг тооцож, Засаг даргын Тамгын газрыг мэргэшсэн мэдлэг чадвар бүхий албан хаагчаар бэхжүүлэхэд зохион байгуулалтын болон мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлж төрийн захиргааны шинэтгэлийн бодлогыг хэрэгжүүлэхэд манлайлан оролцох замаар төрийн захиргааны ажлыг тогтвортой чанартай шуурхай, стандартын дагуу явуулж үр дүнд хүргэх зорилго бүхий аймгийн Засаг даргын харьяа байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөө бага байна.

Баян сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй, нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцүүлэн Сангийн сайдын 2006 оны 388, 2015 оны 341 тоот тушаалаар баталсан загвар, аргачлалыг баримтлан тайлагнаж байна.

Баян сумын Засаг даргын 2020 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн А/94 дүгээр тушаалаар томилогдсон 5 хүний бүрэлдэхүүнтэй баг хяналтыг хэрэгжүүлдэг байна. Аймгийн Засаг даргаас жилд 2 удаа бүх сум байгууллагад нэрэмжит үзлэг, Санхүүгийн хяналт аудитын алба удирдамж төлөвлөгөөний дагуу хяналт шалгалт явуулдаг, байгууллага бүрд дотоод хяналтын нэгж ажилладаг боловч сумын хэмжээнд төсөв санхүүгийн сахилга бат сайжирч, алдаа зөрчил буурахгүй байна. Цаашид анхан шатны болон нягтлан бодох бүртгэл хөтлөлт, хөрөнгийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулах талаар дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Төв аймгийн Баян сумын Засаг даргын дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баян сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн тайлангийн мөнгөн гүйлгээний нийт зарлагыг суурь үзүүлэлтийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл Дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 3,260,597.4 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 48,908.9 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 39,127.1 мянган төгрөгөөр тогтоосон.

Төлөвлөх үе шатанд тооцсон ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Энэ нь төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын үзүүлэлтийг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үзүүлэлтээс тооцсон тул гүйцэтгэлийн үе шатанд дахин тооцох шаардлагатай байна

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 3,901,014.0 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 58,515.2 мянган төгрөгөөр тогтоосон.

Энэ нь төлөвлөлтийн үе шатнаас 9,606.2 мянган төгрөгөөр өссөн байна. Гүйцэтгэлийн материаллаг байдлыг 80 хувиар буюу 46,812.1 мянган төгрөгөөр тогтоолоо.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Төв аймгийн Баян сумын Засаг дарга нь 2021 оны санхүүгийн үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, ЗЗНДНТУТХ, Шилэн дансны тухай хууль, ТБОНӨ-ийн тухай хууль болон холбогдох бусад хууль дүрэм зааврыг мөрдлөг болгон ажиллаж байна.

Санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсөвт байгууллага, төрийн сан, Сум хөгжүүлэх сан, Орон нутгийн хөгжлийн сан, Эмийн эргэлтийн сан, Байгалийн нөхөн сэргээлтийн барьцаа сан зэрэг 11 санхүүгийн тайланг нэгтгэн тайлагнасан байна.

Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд Сангийн яамны Э тайлангийн нэгтгэлийн систем программыг ашиглаж байна.

Орлогын талаар:

Төв аймгийн Баян сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа байгууллагууд тусгай зориулалтын шилжүүлгээс 1,111,619.4 мянган төгрөгийн санхүүжилт, орон нутгийн төсвийн 246,566.1 мянган төгрөгийн санхүүжилт, Эрүүл мэндийн даатгалаас 12,020.8 мянган төгрөгийн санхүүжилт, Орон нутгийн хөгжлийн сангийн 485,335.9 мянган төгрөгийн санхүүжилт, Төсөвт байгууллагын өөрийн орлого 138,537.4 мянган төгрөг, торгуулийн орлого 30,630.8 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтийн дансанд 219,868.5 мянган төгрөг, татварын орлого 245,937.4 мянган төгрөг, нийт 3,530,622.5 мянган төгрөгийн орлого, эх үүсвэрийг төвлөрүүлэн зарцуулсан байна.

Баян сумын ИТХ-ын Хуралдааны 2021 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 03 дугаар тогтоолоор сумын орон нутгийн төсөвт төвлөрүүлэх татварын орлогыг нийт 230,182.7 мянган төгрөгөөр баталсан байна.

Орон нутгийн төсөвт 2021 онд татварын орлого 245,930.2 мянган төгрөг, татварын бус орлого 1,073,901.2 мянган төгрөг, нийт 1,319,831.4 мянган төгрөг төвлөрч, батлагдсан төлөвлөгөөг 788,086.5 мянган төгрөг буюу 2.5 дахин биелүүлсэн байна. Орон нутгийн орлогын төлөвлөгөө өндөр хувиар биелэхэд сумын Засаг даргатай байгуулсан Идлэг шонхор шувуу бариулах тухай гэрээний дагуу 1,037,491.2 мянган төгрөгийн орлого төвлөрсөн нь нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгө, бараа материалын талаар:

Үндсэн хөрөнгө дансанд 8,687.8 мянган төгрөгийн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр, 186,016.9 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй орлогоор нийт 194,704.7 мянган төгрөгийн хөрөнгийг бүртгэсэн ба 54,047.1 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, данснаас хассан байна.

Бараа материалын дансанд худалдан авсан 306,726.6 мянган төгрөгийн, үнэ төлбөргүй хүлээн авсан 194,254.3 мянган төгрөгийн, нийт 500,980.9 мянган төгрөгийн бараа материалыг орлогоор бүртгэж, 490,149.1 мянган төгрөгийн бараа материалыг хассан байна

Авлага, өглөгийн талаар:

Санхүүгийн нэгтгэсэн тайланд байгууллагаас авах 66,361.0 мянган төгрөг, хувь хүмүүсээс авах 131,467.0 мянган төгрөг, эргэлтийн эмийн сангийн авлага 22,728.3 мянган төгрөг, нийт 221,089.3 мянган төгрөгийн авлага нэгтгэгдсэн байна. Нийт авлагын 143,930.0 мянган төгрөг буюу 65,0 хувийг сум хөгжүүлэх сангийн зээлийн авлага эзэлж байна.

Ажилчидтай холбогдсон өглөг 174.6 мянган төгрөг, байгууллагад төлөх өглөг 25,564.0 мянган төгрөг, нийт 25,738.6 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй нэгтгэгдсэн байна.

Санхүүгийн байдлын тайлангийн талаар:

Санхүүгийн байдлын нэгтгэсэн тайланд 2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар төрийн сангийн харилцах дансанд 1,716,197.8 мянган төгрөг, арилжааны банк дахь харилцах дансанд 1,115.7 мянган төгрөг, нийт 1,717,313.6 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл нэгтгэгдсэн байна.

Бараа материал 215,262.3 мянган төгрөг, үндсэн хөрөнгө 4,871,006.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Төв аймгийн Баян сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	399,465.7	1,717,313.6	1,317,847.9
Авлага	225,521.7	221,089.3	-4,432.3
Урьдчилгаа			
Бараа материал	204,430.5	215,262.3	10,831.8
Үндсэн хөрөнгө	4,985,835.9	4,871,006.5	-114,829.4
Нийт хөрөнгө	5,815,253.9	7,024,671.8	1,209,417.9
Өр төлбөр	5,494.4	25,738.6	20,244.2
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	5,809,759.5	6,998,933.2	1,189,173.7
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	5,815,253.9	7,024,671.8	1,209,417.9

Бараа материалын дансны үлдэгдэл 215,262.3 мянган төгрөг болж, оны эхний үлдэгдлээс 10,831.8 мянган төгрөгөөр өссөн нь эм, боох материал, бичиг хэрэг, хүнсний материалын үлдэгдэл өмнөх оноос өссөнөөс шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 4,871,006.5 мянган төгрөг болж 114,829.4 мянган төгрөгөөр буурсан нь элэгдлийн зардлаас шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 6,998,933.2 мянган төгрөг болж 1,189,173.7 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Баян сумын ИТХ-ын Хуралдааны 2020 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн “2021 оны төсөв батлах тухай” 06 дугаар тогтоолоор 2021 онд төсөвт төвлөрүүлэх татварын ба татварын бус орлогыг 531,744.9 мянган төгрөгөөр, зарлагын нийт хэмжээг 2,750,703.4 мянган төгрөгөөр баталсан байна. Сумын ИТХ-ын Хуралдааны 2021 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 02 дугаар тогтоолоор 2021 оны төсвийн жилд орон нутгийн хөгжлийн санд олгох шилжүүлгийн хэмжээг 485,335.9 мянган төгрөгөөр, тусгай зориулалтын шилжүүлгийн хэмжээг 192,180.8 мянган төгрөгөөр тус тус тодотгон баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн зарлагын нийт хэмжээг 2,750,703.4 мянган төгрөгийн төсөв баталсан.

Нийт зардлын 246,566.1 мянган төгрөгийг улсын төсвөөс, 47,049.1 мянган төгрөгийг урьд оны шилжих үлдэгдлээс, 354,206.8 мянган төгрөгийг ОНХС-ийн шилжих үлдэгдлээс, 22,084.7 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 1,065,686.7 мянган төгрөгийг аймгийн төсвөөс тусгай зориулалтын шилжүүлэг, 483,365.1 мянган төгрөгийг аймгаас ОНХС-д санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 1,766,736.3 мянган төгрөгийг урсгал зардалд, 124,997.7 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд, 1,101.3 мянган төгрөгийг эргэн төлөгдөх зээлийн зардалд, нийт 1,892,835.4 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэл 50,731.4 мянган төгрөгийг аймгийн төсөвт, 906,220.7 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,892,835.4 мянган төгрөг буюу 62,7 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд санхүүгийн нэгтгэсэн тайланд 219,868.5 мянган төгрөгийн эх үүсвэрийг төвлөрүүлэн, бараа, ажил үйлчилгээний зардалд 161,878.8 мянган төгрөг, бусад урсгал шилжүүлэг буюу нэг удаагийн мөнгөн тэтгэмж, дэмжлэг, урамшуулалд 33,258.0 мянган төгрөгийг зарцуулж, оны эцэст зарцуулаагүй үлдэгдэл 24,731.7 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Баян сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн төсөвт байгууллагууд, тусгай зориулалттай сангуудын санхүүгийн тайлангийн аудитын талаар:

- Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудиторуд нь тус сумын ЗДТГ-ын санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж, ИТХ, Соёлын төв, ОНХС, СХС, Байгалийн нөхөн сэргээлтийн барьцаа сан, эмийн эргэлтийн сангийн тайланг түүвэрт хамруулан шалгасан. Аудитаар ЗДТГ-т 1 зөвлөмж, ИТХ-д 420.0 мянган төгрөгийн 3 зөвлөмж, соёлын төвд 1,335.4 мянган төгрөгийн 4 зөвлөмж, сум хөгжүүлэх санд 61,330.1 мянган төгрөгийн 1 зөвлөмж, 11,490.1 мянган төгрөгийн 1 албан шаардлага тус тус өгөгдсөн.
- Төв аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний үндсэн дээр Уваа уул аудит ХХК тус сумын ЕБС, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төв гэсэн 3 байгууллагын санхүүгийн тайланд аудит хийж, дүгнэлт гаргасан. Аудитаар эргэлтийн эмийн сангийн санхүүгийн тайланд 41,937.8 мянган төгрөгийн 4 зөвлөмж хүргүүлсэн байна.

3.8 Аудитын гол асуудал

Сумын орлогын төлөвлөгөөг нийт дүнгээр биелүүлсэн боловч 3 нэр төрлөөр тасалсан зөрчилд зөвлөмж өгсөн.

Сумын эргэлтийн эмийн сангийн санхүүгийн тайлангийн аудитаар жилийн эцсийн тооллогын бүртгэл, тооцоо бодсон акт, бусад холбогдох материалыг аудитад ирүүлээгүй, дутсан эмийн төлбөрт тогтоосон төлбөрийн актыг барагдуулаагүй, авлага өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй зөрчлүүдэд зөвлөмж өгсөн.

Сум хөгжүүлэх сангийн авлагын үлдэгдлийг тооцоо хийж, баталгаажуулсан байдал болон зээлийн хугацаа хэтрэлтийг зээлдэгч бүрээр тулгахад 11,490.0 мянган төгрөгийн хугацаа хэтрэлттэй зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цэсэнд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 146 мэдээллээс хугацаандаа мэдээлсэн 136 мэдээлэл, хугацаа хоцроосон 9 мэдээлэл, мэдээлээгүй 1 мэдээлэл байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллага нь санхүүгийн тайлан, аудитад шаардлагатай баримт материалыг жагсаалт үйлдэн файлаар болон цаасаар ирүүлсэн.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн 1 зөвлөмжийн хэрэгжилтийг 2021 оны 6 дугаар сарын 16-ны өдрийн 181 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Баян сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн орлогын талаар дараагийн аудитаар анхаарал хандуулах зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 535,306.7 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 110,442.9 мянган төгрөгийн алдааг залруулж, 24,115.1 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 400,748.7 мянган төгрөгийн зөрчилд 16 зөвлөмж өгөв.

4.1 Залруулсан алдаа

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал 2,629.3 мянган төгрөгийн төсвийн зарцуулаагүй үлдэгдлийн төвлөрүүлэхдээ буруу кодоор тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 8 дугаар зүйлийн 8.1-д “Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргах үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “толилуулга”, “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал 1,549.18 мянган төгрөгийн цалингийн урьдчилгааг урьдчилгаа дансанд бүртгэлгүй цалингийн өглөгөөр бүртгэсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 8 дугаар зүйлийн 8.1-д “Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргах үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д “төсвийн иж

бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “толилуулга”, “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

Соёлын төвийн Мөнгөн гүйлгээний тайланд үндсэн хөрөнгө худалдан авсан 1,679.8 мянган төгрөгийн зардлыг хөрөнгийн зардлаар тайлагнаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 8 дугаар зүйлийн 8.1-д “Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргах үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “толилуулга”, “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

Соёлын төв 6,982.7 мянган төгрөгийн төсвийн зарцуулаагүй үлдэгдлийн төвлөрүүлэхдээ буруу кодоор тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 8 дугаар зүйлийн 8.1-д “Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргах үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “толилуулга”, “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

4.3 Албан шаардлага

Засаг даргын санхүүгийн тайланд нийгмийн хариуцлагын гэрээний дагуу Петрокоал ХХК-аас хүлээн авсан 2,625.0 мянган төгрөгийн 105 тонн нүүрс, Эрдэнэ шувуут ХХК 10,000.0 мянган төгрөгийн замын зураг төсвийг орлогод бүртгэж аваагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.2-д “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага”, 14.4.5-д “бүх орлого” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “оршин байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-дэх заалт болон МУЕА-ын 2020 оны а/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11-д “хууль тогтоомж,

гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэсэн дагуу шийдвэрлэв.

Сум хөгжүүлэх сангийн авлагын үлдэгдлийг тооцоо хийж, баталгаажуулсан байдал болон зээлийн хугацаа хэтрэлтийг зээлдэгч бүрээр тулгахад 11,490.1 мянган төгрөгийн хугацаа хэтрэлттэй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “толилуулга”, “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна..

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д заалт болон МУЕА-ын 2020 оны а/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.7-д “авлага, өглөгийг тооцоо нийлж, баталгаажуулаагүй” бол албан шаардлага өгөх гэсэн дагуу шийдвэрлэв.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Орлоготой холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Сумын орлогын төлөвлөгөөг нийт дүнгээр биелүүлсэн боловч хувь хүний орлогын албан татвар, буу, газрын төлбөр гэсэн 3 нэр төрлөөр тасалсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1-д "Батлагдсан төсвийг хэрэгжүүлэх нарийвчилсан хуваарь, төсвийн дэлгэрэнгүй хуваарилалт, төсвийн зарцуулалт болон бүрдүүлэлтэд тавих хяналтыг төсвийн сар, улирлын батлагдсан хуваарийн дагуу хэрэгжүүлнэ", 41.2.1-д "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн татварын болон татварын бус орлогыг мэдээлэхдээ орлогын дансны хуулгыг боловсруулан үнэн зөв мэдээлж байх ба түүнд тавих хяналтыг сайжруулах

2. Тайлан, мэдээ гаргалттай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Сум хөгжүүлэх сангийн санхүүгийн тайлангийн авлагын үлдэгдлийг аймгийн ХХААГ-аас ирүүлсэн сангийн авлагын дүнтэй тулгахад 61,330,1 мянган төгрөгийн зөрүүтэй тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Сум хөгжүүлэх сангийн авлагын дүнг ХХААГ-ийн тайлангаас зөрүүтэй мэдээлж буй зөрчлийг арилгаж, зээл, зээлийн хүүгийн авлагын үлдэгдлийг зөрүүгүй үнэн зөв тайлагнаж байх.

3. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Эргэлтийн эмийн сан нь Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас тогтоосон 13,553.0 мянган төгрөгийн төлбөрийн актыг барагдуулж ажиллах арга хэмжээ зохион байгуулж ажиллаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага нь хөрөнгө, өр төлбөрөө нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэлж дансанд тусгана”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Дутсан эмийн төлбөрийг яаралтай барагдуулж, цаашид эмийн тооцоог тухай бүр хийж байх.

4. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

4.1. Илрүүлэлт:

Эмийн эргэлтийн сан, иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, соёлын төв нь элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийг дахин үнэлж данс бүртгэлд тусгаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага нь хөрөнгө, өр төлбөрөө нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэлж дансанд тусгана”, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолыг тус тус хэрэгжүүлээгүй, санхүүгийн тайлангийн аудитын “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгүүдийг дахин үнэлж бүртгэх.

5. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал

5.1. Илрүүлэлт:

Эргэлтийн эмийн сан нь авлага, өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, жилийн эцсийн тооллогын бүртгэл, тооцоо бодсон акт, бусад холбогдох материалыг аудитад ирүүлээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалтууд, санхүүгийн тайлангийн аудитын “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Авлага, өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж ажиллах.

6. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал

6.1. Илрүүлэлт:

Соёлын төв нь заалны орлогыг бүртгэхдээ аккруэль сууриар хүлээн зөвшөөрч бүргээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө” гэсэн заалтууд, санхүүгийн тайлангийн аудитын “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Заалны орлогыг бүртгэхдээ аккруэль сууриар хүлээн зөвшөөрч бүргэж байх.

7. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

7.1. Илрүүлэлт:

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь 420.0 мянган төгрөгийн худалдан авалтыг цахим төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4-д “хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалыг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн тайлангийн аудитын “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Худалдан авалт бүрийг төлбөрийн цахим баримтаар баталгаажуулж ажиллах.

8. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

8.1. Илрүүлэлт:

Соёлын төв, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь Шилэн дансны тухай хуулийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д “Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална”, 4.1.3-д “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны цэсэнд мэдээллийг тогтоосон хугацаанд үнэн зөв, бүрэн гүйцэд мэдээлж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 6 дугаар сарын 10 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл /мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа зөрчил		Үүнээс					
				Залруулга		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн
1	Баян Засаг дарга	25	535,306.7	7	110,442.9	2	24,115.1	16	400,748.7